

Хууль, эрх зүйн мэдээлэл #2



**Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл
шалгаруулалтын журам шинэчлэн батлагдлаа**

Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний ахлах менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com


Батзулын Амарбат

Хуулийн үйлчилгээний менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarbat.batzul@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn



Хураангуй

Монгол Улсын Эрчим Хүчний Сайдын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/217 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журмыг шинэчлэн баталлаа. Энэхүү журмаар эрчим хүчний эх үүсвэр барих төслийг нийтэд зарлах, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн шалгаруулах, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулжээ.

Өмнө үйлчилж байсан 2020 оны журамд 1 МВт-аас дээш хүчин чадалтай бүх төрлийн сэргээгдэх эх үүсвэрийг хамруулж байсан бол 2025 оны журамд зөвхөн 6 кВ ба түүнээс дээш хүчдэлд холбогдох нар, салхины төслүүдийг хамруулахаар хязгаарласан байна. Үүний адил шинэчлэн батлагдсан журамд хэд хэдэн анхаарах өөрчлөлтүүд орсныг дараах хүснэгтээс танилцана уу.

Шинэчлэгдсэн зохицуулалтууд:

№	Өөрчлөлтүүд	Шинэчлэн батлагдсан журам (2025 он)
1.	Төсөл шалгаруулалтыг нийтэд зарлах	Төсөл шалгаруулалтын урилгыг урьдчилсан үнэлгээ эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдэгдэх хугацааг 45-аас доошгүй буюу хугацааны хувьд илүү эрт нийтэд зарлахаар өөрчилсөн байна.
2.	Төсөлд оролцох бэлтгэл	1. Төслийн захиалагч буюу журамд заасан эрх бүхий этгээд нь цахим хуудсанд тухайн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хамт нийтлэх бөгөөд үүний дагуу бэлтгэл ажлыг хангахаар зохицуулсан байна. 2. Цахим хуудас байршуулсан маягыг бөглөх 3. Төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргах ба энэхүү баталгаа нь хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 1-5 хувьтай тэнцсэн байна. 4. Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг төрийн захиргааны байгууллагаас авах ба доорх баримтуудыг заавал багтаана. Үүнд: • Сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа • Тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг • Горим, тогтворжилтын тооцоо • Хөрөнгө оруулалт, эдийн засгийн шинжилгээ (WACC, IRR, NPV)
3.	Төсөлд оролцуулагчийн илгээх материал	1. Төсөлд оролцох хүсэлт 2. Хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар (түншлэл бол түншлэлийн оролцогч хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар болон түншлэлийн гэрээ) 3. Талуудын сүүлийн 5 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн баталгаажуулсан хувилбар 4. Байгууллагын өмнөх туршлага
4.	Төслийн техник, эдийн засгийн зардлыг тооцох аргачлал	Зардал=I+P*q+L+T+G+C I - суурь төлбөр - тавин мянган нэгж; P - суурилагдсан хүчин чадал (Ватт); q - итгэлцүүр (нарны цахилгаан станц-3, салхин цахилгаан станц-5); L - газрын төлбөр; T - Эрчим хүчний зохицуулах хорооноос олгох тусгай зөвшөөрлийн хураамж; G - Горим, тогтворжилтын тооцооны төлбөр; C - Бусад зардал (зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан зардал).

№	Өөрчлөлтүүд	Шинэчлэн батлагдсан журам (2025 он)
5.	Төсөл шалгаруулах үе шат	1. Урьдчилсан үнэлгээ: Энэхүү шатанд анх зарлагдсан төсөл үнэлэх шалгуурын дагуу шалгаж, урьдчилсан үнэлгээгээр 5 оролцогчийг шалгаруулна. 2. Техникийн үнэлгээ: Төсөл шалгаруулалтын дараагийн шатанд төсөл шалгаруулалтын хороо нэмэлт баримт бичгүүдийг илгээх урилгыг оролцогчид олгох бөгөөд тухайн баримтуудыг үнэлэн хэрэв техникийн саналд 70 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд эцсийн шатанд оролцох эрхтэй болно. 3. Санхүүгийн үнэлгээ: Төсөл шалгаруулалтын хороо оролцогчдийн санхүүгийн саналыг эрэмбэлж, эх үүсвэрээс 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний хамгийн бага тарифаар (Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар тооцохгүйгээр) санал ирүүлсэн төслийг шалгаруулан зөвлөмж, тайланг төслийн захиалагчид хүргүүлснээс 5 хоногийн дотор өөрийн шийдвэрийг мэдэгдэнэ.
7.	Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах	Төслийн захиалагч төсөл нь шалгарсан оролцогчтой хэлцэл хийх ажлын хэсгийг байгуулж, хамгийн бага тариф санал болгосон оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулна. Үүнээс 5 хоногийн дотор мөн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй байхаар зохицуулсан байна.
8.	Маргаан шийдвэрлэх	Өмнөх журамд зааснаар хэрэв бусад оролцогчид шалгаруулалтын талаар маргаантай байгаа тохиолдолд гомдлыг шууд шүүхэд хүргүүлдэг байсан бол шинэчилсэн журмаар гомдлыг мэдэгдэл хүлээн авснаас 5 хоногийн дотор захиалагчид хүргүүлэх буюу шүүхэд хандахаас өмнө урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар нэмсэн байна.



Бидэнтэй холбогдоорой

Та дээрх болон сэргээгдэх эрчим хүчний эрх зүйн орчны талаар зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу. **Дээрх журмын бүрэн хувилбартай энд дарж танилцана уу.**

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.